



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/250

Мөрөн

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.-гийн "Б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2015 оны эхний хагас жилд Хөвсгөл аймагт гарсан ой хээрийн түймрийг унтраах ажилд зарцуулагдсан шатах тослох материал хоол хүнсний зардалд 9620585 төгрөг, мал амьтны гоц халдварт өвчний голомтод ажилласан зардал, устгасан малын төлбөрт 10857810 төгрөг, Цагаануур сумын Хармай 2 дугаар багийн нутаг Их Жамсын голд гарсан ой хээрийн түймрийг унтраах ажилд томилогсон Хөвсгөл, Архангай аймгийн Онцгой байдлын газар, Хилийн цэргийн 0257 дугаар анги, сумдаас дайчлагдсан цэргийн албыг дүйцүүлэх журмаар хааж буй албан хаагчид нийт 79 хүний 10 хоногийн хоол хүнс, тээврийн хэрэгслүүдийн шатах тослох материалын зардалд 5754180 төгрөг, Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын 4 дүгээр багийн нутаг Арсайн голд зусаж буй айлуудад боом өвчний шинж тэмдэг илэрч олон тооны адуу үхсэн, Чандмань-Өндөр сумын 1 дүгээр баг Баянголд тугал өвчилж үхээд байгаа дуудлагаар аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газраас томилогдсон мэргэжилнүүд өвчний голомт дээр очиж ажиллахад шаардагдах шатахууны зардалд 245820 төгрөгийг холбогдох баримтыг үндэслэн зарцуулсугай.

3. Дээрх зардлуудад шаардагдах 26478395 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга/ Г.Төмөрбаатар/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/ нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР